

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Харгуй ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/21/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Ц.Хатанболд, Б.Ариунаа,

Утас: 91925552, 99195208

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.12 № 333  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харгуй ТӨХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Харгуй ТӨХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 5,454.8 мянган төгрөг, авлага 1,171,782.4 мянган төгрөг, бараа материал 208,514.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,632,842.9 мянган төгрөг, нийт хөрөнгө 5,018,594.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд борлуулалтаас 6,208,721.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 5,226,765.3 мянган төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 761,470.8 мянган төгрөг, санхүүгийн зардалд 49,939.0 мянган төгрөг, бусад зардалд 100,205.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Тайлант онд 62,210.2 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, 9,258.6 мянган төгрөгийн орлогын албан татвар ногдуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар 1526ХЭҮ улсын бүртгэлийн дугаартай МА35902А2-390 загварын авто машин, 1486ХЭҮ улсын бүртгэлийн дугаартай МА310М-01 загварын авто машиныг данс бүртгэлд тусгаагүй байна. Дээрх 2 авто машиныг 2022 онд хүлээн

232420377

авсан боловч төлбөрийг хариуцах эзэн холбогдогч тодорхойгүй, хөрөнгийг хүлээж авахдаа байгуулсан гэрээ хэлцэл байхгүй, хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гараагүй байна.

Ажиллагсдаас авах авлагын 37,737.9 мянган төгрөг буюу 3.2 хувь нь цалингийн урьдчилгааг олговол зохих цалингаас хэтрүүлэн олгож, тухай сард нь суутган тооцдоггүйтэй холбоотой байна. Мөн цалингийн урьдчилгааг нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, тусламж, бараа материалаар хааж байгаа тул цалингийн урьдчилгааг олговол зохих цалинтай уялдуулах шаардлагатай.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 13,472.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнээс 1,023.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 7,445.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 5,003.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант оны цэвэр ашгийг 27.4 сая төгрөгөөр Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосныг 34.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаарахгүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12,464,504.75	5,454,770.03
1.1.2	Дансны авлага	652,748,363.55	1,171,580,692.87
1.1.4	Бусад авлага	201,728.00	201,728.00
1.1.6	Бараа материал	230,244,846.02	208,514,102.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	895,659,442.32	1,385,751,292.90
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,189,844,919.92	3,484,072,897.72
1.2.2	Биет бус хөрөнгө	148,770,000.00	148,770,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,338,614,919.92</b>	<b>3,632,842,897.72</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,234,274,362.25</b>	<b>5,018,594,190.62</b>
2.1.1.1	Дансны өглөг	21,220,257.00	376,347,400.00
2.1.1.3	Татварын өр	73,784,724.69	150,425,633.07
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	6,598,571.00
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	95,004,981.69	533,371,604.07
2.2	Өр төлбөрийн нийт дүн	95,004,981.69	533,371,604.07
2.3.1	Өмч: - төрийн	436,426,000.00	436,426,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	171,465,655.46	171,465,655.46
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,375,149,839.44	3,658,892,867.20
2.3.9	Хуримтлагдсан ашиг	156,227,885.66	218,438,063.88
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,139,269,380.56	4,485,222,586.54
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>4,234,274,362.25</b>	<b>5,018,594,190.61</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,270,752,400.90	6,208,721,314.64
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,478,619,325.42	5,226,765,275.92
3	Нийт ашиг (алдагдал)	792,133,075.48	981,956,038.72
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	1,128,044.78
6	Мал аж ахуйн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	639,932,709.86	761,470,821.30
11	Санхүүгийн зардал	310,500.00	49,938,955.73
12	Бусад зардал	73,645,356.87	100,205,518.71
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	78,244,508.75	71,468,787.75
19	Орлогын татварын зардал	7,824,450.90	9,258,609.53
20	Татварын дараах ашиг (алдагдал)	70,420,057.85	62,210,178.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	70,420,057.85	62,210,178.22
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	70,420,057.85	62,210,178.22
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл</b>	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	133,207,827.82	4,116,249,322.72
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	13,519,672.38	13,519,672.38
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,432,499.84)	(1,432,499.84)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
{2020} оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	145,295,000.36	4,128,336,495.26
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	62,210,178.22	62,210,178.22
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
<b>2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	207,505,178.58	4,190,546,673.48

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,350,355,671.00	6,452,210,453.09
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,824,416,077.00	6,265,104,036.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	525,939,594.00	187,106,417.09
1.2	Мөнгөн зарлага (-)	5,838,772,529.28	6,193,306,946.39
	Ажиллагчдад төлсөн	642,617,277.00	858,886,638.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	215,584,331.29	266,379,790.70
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,192,090,130.30	1,916,709,130.45
	Ашиглалтын зардалд төлсөн	31,797,999.85	69,773,661.21
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,293,777,153.67	1,641,773,073.24
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	45,778,865.32
	Татварын байгууллагад төлсөн	123,787,667.77	243,660,413.26
	Даатгалын төлбөрт төлсөн	7,885,840.00	8,284,680.00
	Бусад мөнгөн зарлага	1,331,232,129.40	1,142,060,694.21
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	511,583,141.72	258,903,506.70
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	1,128,044.78
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	1,128,044.78
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	479,360,509.00	267,041,286.20
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	479,360,509.00	267,041,286.20
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(479,360,509.00)	(265,913,241.42)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	390,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	390,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,400,000.00	390,000,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	390,000,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	47,400,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(47,400,000.00)	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(15,177,367.28)	(7,009,734.72)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,641,872.03	12,464,504.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,464,504.75	5,454,770.03



цалин, нөхөн олговрыг давхардуулан олгосон.											
Цалингийн санг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 7.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	7,445.2			1	7,445.2					
Зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарыг бар имтлаагүй байна.	1	5,003.3					1	5,003.3			
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>13,472.3</b>	<b>1</b>	<b>1,023.7</b>	<b>1</b>	<b>7,445.2</b>	<b>1</b>	<b>5,003.3</b>			

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			